



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

**ШУДАРГА ӨРСӨЛДӨӨН,
ХЭРЭГЛЭГЧИЙН ТӨЛӨӨ ГАЗАР**

15141 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Ж.Самбуугийн гудамж, Засгийн газрын XI байр,
Утас: 26 26 53, Факс: (976-11) 32 00 41

2019.03.06 № 1/296
танай _____-ны № _____-т

Тендерийн баримт бичиг хянасан тухай

Танай газраас зарласан “Даатгалын үйлчилгээний тухай” НЦГ/201912001 дугаартай тендерийн баримт бичигт холбогдох гомдлыг “Номин даатгал” ХХК-аас тус газарт ирүүлсний дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу хянаж үзлээ.

Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтийн 12.1.5-д “Санхүүгийн зохицуулах хорооноос салбарын мэдээллийн буюу нийслэл, төв, орон нутагт санхүүгийн идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй салбарын тоо аймаг бүрт 1-ээс доошгүй, төлөөлөгч хүн сум бүрт 1-ээс доошгүй байх тодорхойлолт болон салбарт ажиллаж байгаа ажилчид, төлөөлөгч хүмүүсийн НДШ төлсөн тухай НД-ын баталгаажсан тайлангийн хамт ирүүлнэ” гэж заасан байна.

Үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл болон холбогдох тайлбар зэргээс үзэхэд сум бүрт 1-ээс доошгүй даатгалын төлөөлөгчтэй байх шаардлагыг хангах, өрсөлдөх чадвар бүхий аж ахуй эрхлэгчид байгаа эсэх нь тодорхой мэдээлэл, судалгаанд үндэслээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой... байх зарчмыг баримтална.” гэж заасныг зөрчсөн гэж үзэхээр байна.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3.3-т “зөрчлийг арилгасны үндсэн дээр тендер шалгаруулалтыг явуулахыг захиалагчаас шаардаж, хэрхэн шийдвэрлэсэн талаар хариу мэдэгдэж, тендер шалгаруулалтыг үргэлжлүүлэн явуулахыг үүгээр мэдэгдэж байна.

Хувийг: “Номин даатгал” ХХК-д

ДАРГА

Б.ЛХАГВА

01100130